

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ УРИЛГА

2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Соёлын яам нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Цахим соёл” арга хэмжээний 2.2.4 “Нэг хуудас” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Оюуны өмч ашиглалтыг бүртгэх, хэрэглээг хянах тоолуурын системийн нөхцөл байдлын судалгаа хийж, процессын зураглал, бизнес шинжилгээ хийх” зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

**Санхүүжилтийн эх үүсвэр:** Улсын төсөв, Цахим соёл хөтөлбөр, арга хэмжээний зардал  
**Нийт төсөвт өртөг:** 70,000,000 /Далан сая/ төгрөг  
**2023 онд санхүүжих дүн:** 70,000,000 /Далан сая/ төгрөг

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 онуудад ижил төстэй ажил хийж байсан эсэх болон ажлын туршлага;
- Ажиллах боловсон хүчин, чадавхын талаарх мэдээлэл;
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Сүүлийн 3 жил буюу 2020, 2021, 2022 онуудын борлуулалтын орлогын мэдээлэл

Сонирхсон этгээд дээрх мэдээллийг 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 10 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр ирүүлнэ үү.

Хаяг: Соёлын яам,  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, Денверийн гудамж, Соёлын яамны байр, 109 тоот.

Холбогдох мэдээллийг лавлах утас: 51-265620

Хянасан: СЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга  
Т.Бямбасүрэн

Боловсруулсан: ЦБМТХ-ийн мэргэжилтэн З.Энхгэрэл